

Бараа нийлүүлэлтэнд тавигдах шаардлага, стандарт

1. Бусад хүнсний материал

Хүнсний төрлийн бүтээгдэхүүнд:

Нийлүүлж буй **цагаан будаа, шар будаа, вандуй, гурвалжин будаа, хүүхдийн будаа, хөц будаа, БГ-055, БГ-085, БГ-075, БГ-115 ангилалын гурил нь:** Хүнсний аюулгүй байдал, хорио цээрийн шаардлагыг хангасан байх. Үүнд: Сав, баглаа боодол гэмтээгүй, гадны бохирдолгүй, хогт хольцгүй, ургамлын гадаад дотоод хорио цээргүй, хөнөөлт шавьжгүй, хөгц мөөгөнцөр илрээгүй, өөрийн төрөлдөө тохирсон үнэр амт, нэр төрлийн дагуу өнгөтэй, хуурай нунтаг, бөөгнөрсөн хэсэггүй байх. Мөн химийн шинжилгээгээр: хүчиллэг, чийглэг, цавуулаг, үнслэг чанар нь стандартанд тохирч байх шаардлагатай. Хадгалалт, савлалт, борлуулалтын явцад бүтээгдэхүүн тус бүрийг тодорхой үзүүлэлтээр улирал бүр шинжилгээнд хамруулсан шинжилгээний бичгийг авчирч өгч байх.

Гоймонгийн төрлүүд нь: нэр төрөлдөө тохирсон амт, цагаан саарал өнгөтэй, гадаргуу хугарч үйрээгүй, хөгц мөөгөнцөр илрээгүй, гашуун исгэлэн буюу гадны амт үнэргүй, төмрийн хольцгүй, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч болон төмсний савханцар илрээгүй, чийглэг, хүчиллэг, төмөрлөгийн үзүүлэлт нь чанарын шаардлага хангасан зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

2. Хүнсний ногоо

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Стандарт
1	Сонгино	MNS 0260:1982
2	Төмс	MNS 258-2006
3	Байцай	MNS 0255-2007
4	лууван	MNS 0270-1982

Хүнсний ногооны төрөлд: Төмс, байцай, сонгино, лууван, манжин, хүрэн манжин, цэцэгт байцай, улаан лооль, өргөст хэмх багтана.

Төмс: Гадаад байдал нь бүтэн сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, хөндлөн огтлолын өнгө цагаан шар, хальсны бэхжилт сайн, 1ш-ийн жин 114,6гр-249,7гр, голчийн хэмжээ 62-86мм, гадаргуу нь хүрэнтэж зөөлрөөгүй, хөндий үүсээгүй байх шаардлагатай.

Байцай: Сортынхоо хэлбэрийг хадгалсан, гадны амт үнэргүй, хөнөөлт шавьжинд идэгдээгүй, хөлдөлт хайрагдалтгүй, өнгө цайвар ногооноос ногоон байх.

Лууван: Сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, өнгө жигд улаан шаргал, гадны амт үнэргүй, хортонд гэмтэж өвчлөөгүй, дотроо хөндийрөөгүй, өлсөж үрчийгээгүй голч хэмжээ нь 1,9-2,8см байх шаардлагатай.

Сонгино: Сайн сортын хэлбэр дүрсээ хадгалсан, бөөрөнхий хэлбэртэй, гадаргуу хуурай, өвчлөлтгүй, хөндлөн огтлол дахь өнгө цагаан шар, 1ш-ийн жин нь 56,8-82,6гр, механик гэмтэлгүй байх.

Хүнсний ногоог зориулалтын зооринд стандартын дагуу зөв хадгалсан байх.

Техникийн тодорхойлолтууд

“Хүүхдийн хоолны материал” 1. Бусад хүнсний материалын техникийн тодорхойлолт

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	<ul style="list-style-type: none">❖ Өнгө үзэмж, амт, чанарын шаардлага хангасан байх❖ Зориулалтын агуулахтай байх❖ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх❖ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх❖ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна❖ Сав баглаа боодлын стандарт шаардлага хангасан байх❖ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх❖ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх❖ Үйлдвэрлэсэн огноо, ашиглагдах хугацаа шаардлага хангасан байх❖ Нийлүүлэгч нь 2-оос доошгүй жил ажилласан байна❖ Бусад:<ul style="list-style-type: none">Гурил: 1-р зэргийн гурил нь цагаан буюу шаравтар цагаан туяатай цагаан, буудайн гурилын хэвийн үнэртэй, исгэлэн болон гашуун чихэрлэг амтгүй, зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл зажлагдахгүй.Хүүхдийн будаа: 1 кг-ын уутаар савласан байх, тунгалаг биш өтгөн нэгэн жигд цагаан өнгөтэй, ширхэг бүхий хүүхдийн будааны хэвийн үнэртэй, исгэлэн, хөгц зэрэг гадны үнэргүй хэвийн амттай, исгэлэн, гашуун зэрэг гадны ямар нэг амтгүй зажлахад элсэрхэг буюу хатуу зүйл зажлагдахгүй байна.Шар, цагаан, хөц, гурвалжин будаанууд: 1 кг-ын уутаар савласан байх, ургалт бүрэн гүйцсэн, бөөрөнхий хэлбэртэй, элдэв хог хаягдалгүй, хээгүй.Элсэн чихэр: жигд нарийн ширхэгтэй, цагаан өнгөтэй, өөрийн төрлийн үнэртэй чихэрлэг амттай, уусалт сайн, гадны хольцгүй.Ургамлын тос: цайвар шар өнгөтэй, цэвэр тунгалаг, тунадас үүсээгүй,

зориулалтын саванд савласан гаж үнэргүй, өөрийн амттай.

Давс: иоджуулсан, зориулалтын уутанд савласан.

Гоймонгууд: гадаргуу нь шулуун эржгэр долгиолсон буюу туузан хэлбэртэй, нэр төрөл ангилалдаа тохирсон элдэв амт, үнэргүй хөгцөрсөн гашуун, исгэлэн буюу гадны үнэр амтгүй, савлалт тээвэрлэлтийн явцад үйрч няцраагүй, шаргал буюу цайвар шаргал өнгөтэй.

Хөөлгөгч: шаргал туяатай, сааралдуу өнгөтэй, бараан толбогүй, гадны ямар нэгэн амтгүй, задлахад нунтаг байдалтай, хуурай наалдаагүй, хадгалах хугацаа хэтрээгүй.

Үзэм: хүрэн бор, шаргал өнгөтэй, чихэрлэг, гадны гаж амтгүй, шороо чулуугүй, эрүүл ахуйн шаардлага хангасан.

Хар чавга, чангаанз: гадны бохирдолгүй, гаж үнэр амтгүй, өөрийн амт үнэртэй

Вандуй, эрдэнэ шиш: 450 гр-ын савтай байх, савны битүүмжлэл алдагдаагүй хонхойж савны хэлбэр алдагдаж гэмтээгүй байх

Олон жимсний чанамал: 860гр савтай. Жимсний өөрийн амттай исэж гашуун амт ороогүй.

Нэрс, гишүүнэгний чанамал: өөрийн жимсний амт үнэртэй, исэж гашуун амт ороогүй. гадны бохирдолгүй байна. Монголын хөрсөнд ургасан, гадны хольц, иш навч, шилбэнээс нь салгасан, эсээгүй, няцраагүй, амт, өнгө, үнэр өөрчлөлтгүй, гүйцэт болсон жимсээр чанасан, орц норм жигд

Сүү: 1л-ийн хайрцагтай сүү, 4% тослогтой гашлаж муудаагүй байх

Аньс, чацаргана: Гадны хог бохирдолгүй, исэж элдэв үнэр амт ороогүй байх. Эх орны хөрсөнд ургасан, ямар нэгэн хольцгүй, өнгө үзэмж амт чанарт өөрчлөлт ороогүй, зөв хадгалагдсан, химийн болон нян судлалын шинжилгээ хийгдсэн, хагарч няцраагүй, стандарт хангасан

Печень: сав баглаа боодол бүрэн бүтэн байх, үйрч бутраагүй байна. гадны элдэв үнэр амт ороогүй байна.

Масло: элдэв амт үнэргүй бохирдолгүй байх

Зөгийн бал: сав баглаа боодол бүрэн бүтэн байх

Далайн байцай/шөлний/: Солонгос улсынхтай дүйцхүйц, хадгалах хугацаа дуусаагүй, хадгалалт тээвэрлэлтийн горим алдагдаагүй, сав баглаа боодол гэмтээгүй, эвгүй амт үнэр ороогүй, нян судлалын шинжилгээ хийгдсэн, стандартын шаардлага хангасан, 50гр-аар савласан

“Хүүхдийн хоолны материал” 2. Хүнсний ногооны техникийн тодорхойлолт

№	Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага
1	<ul style="list-style-type: none"> ❖ Өнгө үзэмж, амт, чанарын шаардлага хангасан байх ❖ Зориулалтын агуулахтай байх ❖ Эрүүл ахуйн шаардлага хангасан байх ❖ Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн байх ❖ Тээвэрлэлт, хадгалалт хамгаалалтын стандарт шаардлагыг хангасан байна ❖ Сав баглаа боодлын стандарт шаардлага хангасан байх ❖ Шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх ❖ Нийлүүлэх бүтээгдэхүүний гарал үүслийг тендерийн бичиг баримтанд тусгаж өгсөн байх ❖ Үйлдвэрлэсэн огноо, ашиглагдах хугацаа шаардлага хангасан байх ❖ Нийлүүлэгч нь 2-оос доошгүй жил энэ салбарт ажилласан байна ❖ Бусад: <p>Төмс: 1-р зэргийн шинэ эрүүл, шар өнгөтэй, өвчин, хөнөөлт шавьжаар гэмтээгүй, бүтэн, хуурай, сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан байна. 150 грамаас том байна. Өөр төрлийн амт, үнэргүй байна</p> <p>Лууван: 1-р зэргийн шинэ, эрүүл, өнгө нь жигд хэвийн сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, хальс нь хатуураагүй, гадны амт үнэргүй байна.</p> <p>Нягт шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй байна. 150 граммаас том байна</p> <p>Байцай: 1-р зэргийн толгой нь сайн нягтарсан шинэ, бүтэн цэвэр, гаднын үнэр амтгүй байна.</p> <p>Сонгино: Ялзарч муудаагүй, чанартай, эрүүл, шинжилгээний бичигтэй хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой, шаардлага хангасан.</p> <p>Шар манжин, хүрэн манжин: 1-р зэргийн шинэ, эрүүл, өнгө нь жигд хэвийн сортынхоо хэлбэр дүрсийг хадгалсан, хальс нь хатуураагүй, гадны амт үнэргүй байна.</p> <p>Нягт шүүслэг, хөндийрөөгүй, модорч хөгшрөөгүй байна. 150 граммаас том байна</p> <p>Чинжүү: Ялзарч муудаагүй бүтэн өөрийн шинжийг хэвээр хадгалсан байх</p> <p>Улаан лооль: Ялзарч муудаагүй, өнгө үзэмж сайтай, үрлэн хэлбэртэй байх</p> <p>Өргөст хэмх: хонхойж муудаагүй байх</p> <p>Брокколи: Монгол хөрсөнд ургасан, бүрэн болцтой, шавьж хорхойд идэгдээгүй, гэмтэлгүй, зориулалтын зооринд зөв хадгалсан, химийн болон нян судлалын шинжилгээ хийгдсэн, стандарт хангасан, ногоон өнгөтэй</p>

Ажлын хэсэг:Нярав /Б.Лхагвадулам/

.....Эмч /Н.Цэрэндэжид /

.....Ахлах тогооч / Г.Цэнд-Аюуш /

.....Туслах багш /Б.Дэлгэрмаа/

.....Арга зүйч /Т.Эрдэнэчимэг/

